

“ХААН СОЁМБО АУДИТ”- ХХК



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Хөвсгөл аймгийн Баянзүрх сумын ерөнхий боловсролын сургуулийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн аудитын тайлан

Аудитын код: ХӨА-2026/138/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: www.audit.mn
Хөвсгөл аймаг
2025 он

Аудитын газрын дарга,
тэргүүлэх аудитор: А.Эрдэнэбаатар
Утас: 88883317 Цахим хаяг: erdenebaatara@audit.gov.mn

Аудитын менежер: Б.Тэгшдэлгэр
Утас: 99089114 Цахим хаяг: tegshdelgerb@audit.gov.mn

Аудитор: Л.Мөнх-Оргил
Утас: 99039344 Цахим хаяг: munkh-orgill@audit.gov.mn

Хаан соёмбо аудит ХХК-ын захирал: Х.Диймаа
Утас: 99065668 Цахим хаяг: info@khaansoyomboaudit.mn

Ахлах аудитор: Г.Заяа
Утас: 95648028, 98828028
Цахим хаяг: zaya96884510@gmail.com

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



**ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

АЗДТГ-ын байр, А корпус 3 давхар,
Мөрөн сум, Хөвсгөл аймаг, 67120
Утас/факс: 7038 3793, Цахим шуудан: khuvsgul@audit.gov.mn
Цахим хуудас: www.audit.mn

2026.02.25 № 01/116
танай _____-ны № _____-т

ХӨВСГӨЛ АЙМГИЙН
БАЯНЗҮРХ СУМЫН ЕРӨНХИЙ
БОЛОВСРОЛЫН СУРГУУЛИЙН
ЗАХИРАЛ М.ЭРДЭНЭЧУЛУУН
ТАНАА

Хараат бус аудиторын дүгнэлт

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Хөвсгөл аймгийн Баянзүрх сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Баянзүрх сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг

Тайлант онд улсын төсвөөс санхүүжих дүнг 87,430.4 мянган төгрөгөөр, орон нутгийн төсвөөс санхүүжих дүнгээс 30,576.0 мянган төгрөгөөр тус тус дутуу санхүүжүүлсэн байна.

Аудитын гол асуудал

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Аудитаар цалин олголттой холбоотой 2,980.9 мянган төгрөгийн, дотоод хяналт, хариуцлагатай холбоотой 57,279.0 мянган төгрөгийн зөрчил илэрч холбогдох шийдвэрийг гаргасан болно.

Бусад асуудлын хэсэг

Баянзүрх сумын Ерөнхий боловсролын сургууль нь 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 6 зорилтын хүрээнд 28 арга хэмжээ төлөвлөж, хэрэгжилтийг 85.0 хувьтай тайлагнасан байна.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.


Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  А.ЭРДЭНЗБААТАР



2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлан			/Төгрөгөөр/
Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>453,006,075.83</u>	<u>308,509,387.87</u>
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	235,455,934.27	27,468,760.41
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	235,455,934.27	27,468,760.41
3121	Төгрөг	235,455,934.27	27,468,760.41
31211	Төрийн сангийн харилцах	235,455,934.27	27,468,760.41
33	АВЛАГА	257,909.16	5,854,000.00
33200	Төлбөртэй үйлчилгээний авлага	00.00	5,854,000.00
35	БАРАА МАТЕРИАЛ	217,292,232.40	275,186,627.46
35300	Бэлэн бүтээгдэхүүн	18,511,183.04	21,930,051.10
354	Хангамжийн материал	197,005,049.36	251,586,576.36
35410	Бичиг хэргийн материал	3,969,780.00	1,315,980.00
35420	Аж ахуйн материал	161,064,776.35	179,794,876.35
35440	Түлш, шатах тослох материал	218,065.00	13,282,350.00
35450	Барилгын засварын материал	8,026,500.00	257,500.00
35460	Хүнсний материал	14,350,568.01	46,462,270.01
35470	Бусад хангамжийн материал	9,375,360.00	10,473,600.00
35600	Мал амьтад	1,130,000.00	1,670,000.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	<u>5,139,900,545.26</u>	<u>4,838,529,332.63</u>
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	5,139,900,545.26	4,838,529,332.63
392	Биет хөрөнгө	5,029,723,617.08	4,732,179,332.83
39201	Барилга, байгууламж, орон сууц	5,367,954,540.93	5,323,924,834.23
39202	Хуримтлагдсан элэгдэл	1,007,158,919.04	-1,151,595,177.96
39203	Авто-тээврийн хэрэгсэл	83,800,000.00	83,800,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-20,060,416.72	-33,402,083.44
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	581,578,861.80	615,193,761.80
39206	Хуримтлагдсан элэгдэл	-172,376,160.24	-277,665,608.62
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	178,813,368.80	178,813,368.80
39208	Хуримтлагдсан элэгдэл	-117,884,268.03	-132,447,571.52
39214	Бусад үндсэн хөрөнгө	50,809,000.00	50,809,000.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	-1,102,066.87	-11,263,866.91
39217	Ном	85,349,676.45	86,012,676.45
393	Биет бус хөрөнгө	110,176,928.18	106,349,999.80
39301	Програм хангамж	14,104,535.30	14,104,535.30
39302	Хуримтлагдсан элэгдэл	-9,927,607.12	-13,754,535.50

39303	Бусад биет бус хөрөнгө	106,000,000.00	106,000,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>5,592,906,621.09</u>	<u>5,147,038,720.50</u>
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	<u>163,829,608.50</u>	<u>153,552,384.44</u>
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР		
		163,829,608.50	153,552,384.44
413	Өглөг	163,829,608.50	153,552,384.44
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	00.00	2,748,543.79
41320	Бараа үйлчилгээний зардлын өглөг	12,533,112.50	20,098,024.65
4136	Бусад өглөг	151,296,496.00	130,705,816.00
41361	Байгууллагад төлөх өглөг	151,296,496.00	130,705,816.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	<u>5,429,077,012.59</u>	<u>4,993,486,336.06</u>
51	Засгийн газрын хувь оролцоо	5,429,077,012.59	4,993,486,336.06
511	Засгийн газрын оруулсан капитал	1,403,305,822.70	1,403,305,822.70
51101	Өмч: - төрийн	1,403,305,822.70	1,403,305,822.70
512	Хуримтлагдсан үр дүн	3,342,939,951.36	2,951,377,483.17
51210	Өмнөх үеийн үр дүн	3,342,939,951.36	3,386,968,159.70
51220	Тайлант үеийн үр дүн	00.00	-435,590,676.53
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	682,831,238.53	638,803,030.19
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	<u>5,592,906,621.09</u>	<u>5,147,038,720.50</u>

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Хүснэгт 2. Санхүүгийн үр дүнгийн тайлан
/Төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	3,612,212,280.80	3,964,017,289.06
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	154,148,680.80	21,695,989.06
120	Нийтлэг татварын бус орлого	154,148,680.80	21,695,989.06
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	154,148,680.80	21,695,989.06
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	3,337,800.00	8,500,300.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	17,744,600.00	2,231,921.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	133,066,280.80	10,963,768.06
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	3,458,063,600.00	3,942,321,300.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	3,335,063,600.00	3,804,897,300.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	3,335,063,600.00	3,804,897,300.00

1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	123,000,000.00	137,424,000.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	123,000,000.00	137,424,000.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	3,655,998,980.49	4,361,903,115.61
21	УРСГАЛ ЗАРДАЛ	3,655,998,980.49	4,361,903,115.61
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	3,559,674,194.89	4,222,818,634.18
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	2,517,803,758.86	3,057,423,946.81
210101	Үндсэн цалин	1,532,343,796.79	1,774,126,864.82
210102	Нэмэгдэл	844,965,833.46	1,031,306,634.70
210103	Унаа хоолны хөнгөлөлт	00.00	81,868,673.78
210104	Урамшуулал	140,494,128.61	170,121,773.51
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	315,993,900.00	384,018,400.00
210201	Тэтгэврийн даатгал	216,164,448.00	261,132,600.00
210202	Тэтгэмжийн даатгал	25,279,600.00	30,721,500.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	11,351,052.00	15,360,700.00
210204	Ажилгүйдлийн даатгал	12,639,700.00	15,360,700.00
210205	Эрүүл мэндийн даатгал	50,559,100.00	61,442,900.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	133,328,559.50	116,912,615.72
210301	Гэрэл, цахилгаан	35,032,024.50	45,919,290.72
210302	Түлш, халаалт	94,297,435.00	65,993,265.00
210303	Цэвэр, бохир ус	3,999,100.00	5,000,060.00
2104	Хангамж, бараа материалын зардал	76,764,301.87	59,669,880.00
210401	Бичиг хэрэг	13,226,568.00	29,086,800.00
210402	Тээвэр, шатахуун	23,273,590.00	17,778,920.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	40,264,143.87	12,804,160.00
2105	Нормативт зардал	153,154,203.40	215,267,298.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	1,162,560.00	646,000.00
210502	Хоол, хүнс	151,991,643.40	214,621,298.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	10,898,000.00	23,734,400.00
210604	Урсгал засвар	10,898,000.00	23,734,400.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	21,662,803.36	38,207,747.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	6,297,500.00	8,500,321.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	15,365,303.36	29,707,426.00

2109	Бараа үйлчилгээний бусад зардал	330,068,667.90	327,584,346.65
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	40,807,092.00	28,510,084.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	277,298,075.90	299,074,262.65
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	96,324,785.60	139,084,481.43
2132	Бусад урсгал шилжүүлэг	96,324,785.60	139,072,410.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	84,344,352.60	139,072,410.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	00.00	12,071.43
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	00.00	12,071.43
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	-43,786,699.69	-397,885,826.55
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	2,515,000.00	37,704,849.98
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	00.00	36,574,849.98
225005	Үнэ төлбөргүй гарсан зардал	2,515,000.00	1,130,000.00
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	-2,515,000.00	-37,704,849.98
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	-46,301,699.69	-435,590,676.53

2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Хүснэгт 3. Өмч өөрчлөлтийн тайлан
/Төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	1,403,305,822.70	682,831,238.53	3,342,939,951.36	5,429,077,012.59
	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт			44,028,208.34	44,028,208.34
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	0	-44,028,208.34		-44,028,208.34
D08	Тайлант үеийн үр дүн	0	0	-435,590,676.53	-435,590,676.53
D09	2025 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,403,305,822.70	638,803,030.19	2,951,377,483.17	4,993,486,336.06

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Хүснэгт 4. Мөнгөн гүйлгээний тайлан

/Төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	3,479,146,000.00	3,953,053,521.00
ТАТВАРЫН БУС ОРЛОГО	21,082,400.00	10,732,221.00
Нийтлэг татварын бус орлого	21,082,400.00	10,732,221.00
Төсөв байгууллагын өөрийн орлого	21,082,400.00	10,732,221.00
Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	3,337,800.00	8,500,300.00
Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	17,744,600.00	2,231,921.00
ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	3,458,063,600.00	3,942,321,300.00
Улсын төвлөрсөн төсвөөс	3,335,063,600.00	3,804,897,300.00
Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	3,335,063,600.00	3,804,897,300.00
Орон нутгийн төсвөөс санхүүжих	123,000,000.00	137,424,000.00
Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	123,000,000.00	137,424,000.00
НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	3,323,682,963.78	4,133,237,694.86
УРСГАЛ ЗАРДАЛ	3,323,682,963.78	4,133,237,694.86
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	3,218,777,830.78	3,990,616,673.43
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	2,516,574,955.42	3,054,417,493.86
Үндсэн цалин	1,531,114,993.35	1,771,120,411.87
Нэмэгдэл	844,965,833.46	1,031,306,634.70
Унаа хоолны хөнгөлөлт	00.00	81,868,673.78
Урамшуулал	140,494,128.61	170,121,773.51
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	315,993,900.00	384,018,400.00
Тэтгэврийн даатгал	214,875,800.00	261,132,600.00
Тэтгэмжийн даатгал	25,279,600.00	30,721,500.00
ҮОМШӨ-ний даатгал	12,639,700.00	15,360,700.00
Ажилгүйдлийн даатгал	12,639,700.00	15,360,700.00
Эрүүл мэндийн даатгал	50,559,100.00	61,442,900.00
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	113,000,000.00	122,411,928.57

Гэрэл, цахилгаан	25,000,000.00	57,987,928.57
Түлш, халаалт	85,000,000.00	59,424,000.00
Цэвэр, бохир ус	3,000,000.00	5,000,000.00
Нормативт зардал	113,120,890.00	242,236,460.00
Хоол, хүнс	113,120,890.00	242,236,460.00
Эд хогшил, урсгал засварын зардал	10,000,000.00	15,000,000.00
Урсгал засвар	10,000,000.00	15,000,000.00
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	22,703,803.36	52,556,247.00
Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	6,297,500.00	8,500,321.00
Мэдээлэл, технологийн үйлчилгээ	16,406,303.36	44,055,926.00
Бараа үйлчилгээний бусад зардал	127,384,282.00	119,976,144.00
Бараа үйлчилгээний бусад зардал	107,191,982.00	104,502,944.00
Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	20,192,300.00	15,473,200.00
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	104,905,133.00	142,621,021.43
Бусад урсгал шилжүүлэг	104,905,133.00	142,608,950.00
Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	92,924,700.00	142,608,950.00
Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	00.00	12,071.43
Төвлөрүүлэх шилжүүлэг	00.00	12,071.43
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	<u>155,463,036.22</u>	<u>-180,184,173.86</u>
ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	97,897,294.30	27,803,000.00
ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	97,897,294.30	27,803,000.00
Дотоод эх үүсвэрээр	97,897,294.30	27,803,000.00
Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	97,897,294.30	27,803,000.00
ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	<u>-97,897,294.30</u>	<u>-27,803,000.00</u>
НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	57,565,741.92	-207,987,173.86
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	177,890,192.35	235,455,934.27
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	235,455,934.27	27,468,760.41

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Хүснэгт 5. Төсвийн гүйцэтгэлийн тайлан

/Төгрөгөөр/

Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
Татаас, санхүүжилтийн орлого	4,275,932,200.00	3,953,053,500.00	322,878,700.00	95.60%
Улсын төсвөөс	3,892,327,700.00	3,804,897,300.00	87,430,400.00	98.40%
Орон нутгийн төсвөөс	137,424,000.00	137,424,000.00	0.00	100.00%
Туслах үйл ажиллагааны орлого	2,231,900.00	2,231,900.00	0.00	100.00%
Төсөвт байгууллагын үйл ажиллагааны хүрээнд бий болсон орлого	8,500,300.00	8,500,300.00	0.00	27.60%
Урд оны үлдэгдлээс санхүүжүүлэх	235,448,300.00	0	235,448,300.00	
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	4,275,932,200.00	3,953,053,500.00	322,878,700.00	96.40%
НИЙТ ЗАРЛАГЫН ДҮН	4,275,932,200.00	4,161,040,673.86	114,891,526.14	97.3
Ажиллагчидтай холбогдсон зардал	3,533,896,000.00	3,438,435,893.86	95,460,106.14	88.80%
Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил	3,141,240,600.00	3,054,417,493.86	86,823,106.14	96.90%
Цалин	1,960,150,200.00	1,771,120,411.87	189,029,788.13	85.10%
Цалингийн тусгай нэмэгдлүүд	1,181,090,400.00	1,283,297,081.99	-102,206,681.99	143.70%
Нийгмийн хамгааллын шимтгэл	392,655,400.00	384,018,400.00	8,637,000.00	95.20%
Тэтгэвэр болон тэтгэмжийн шимтгэл	329,830,600.00	322,575,500.00	7,255,100.00	95.80%
Эрүүл мэндийн даатгалын хураамж	62,824,800.00	61,442,900.00	1,381,900.00	93.70%
Байр ашиглахтай холбоотой тогтмол зардал	122,424,000.00	122,411,928.57	12,071.43	100.00%
Гэрэл цахилгааны зардал	58,000,000.00	57,987,928.57	12,071.43	59.30%

Түлш, халаалтын зардал	59,424,000.00	59,424,000.00	0.00	116.50 %
Цэвэр, бохир усны зардал	5,000,000.00	5,000,000.00	0.00	143.70 %
Үйл ажиллагаатай шууд холбоотой зардал	463,520,100.00	457,583,901.43	5,936,198.57	82.30%
Хоол	242,239,100.00	242,236,460.00	2,640.00	100.00 %
Бусад бараа үйлчилгээний зардал	136,345,000.00	132,305,944.00	4,039,056.00	.99.9%
Мэдээллийн технологийн зардал	45,757,700.00	41,755,781.01	4,001,918.99	79.80%
Хичээл сургалт, үйлдвэрлэлийн дадлагын зардал	15,678,000.00	15,473,200.00	204,800.00	97%
Урсгал засварын зардал	15,000,000.00	15,000,000.00	0.00	100%
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	8,500,300.00	10,812,516.42	-2,312,216.42	100.00 %
Урсгал шилжүүлэг	156,092,100.00	142,608,950.00	13,483,150.00	
Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	156,092,100.00	142,608,950.00	13,483,150.00	97.70%

3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 35,828.8 мянган төгрөгийн алдаа илэрснээс аудитын явцад 35,828.8 мянган төгрөгийн алдааг залруулсан. Үүнд:

- ✓ Санхүүгийн байдлын тайланд өглөгийн үлдэгдлийг 533.7 мянган төгрөгөөр, авлагын үлдэгдлийг 5,854.0 мянган төгрөгөөр, үр дүнгийн тайланд зардлыг 29,441.1 мянган төгрөгөөр алдаатай тайлагнасныг захирал, нягтлан бодогч нар хүлээн зөвшөөрч залруулга хийсэн.

Аудитаар нийт 60,259.9 мянган төгрөгийн зөрчил илэрснээс 2,980.9 мянган төгрөгийн зөрчилд төлбөрийн акт тогтоон, 56,599.0 мянган төгрөгийн зөрчилд албан шаардлага, дотоод хяналт, нягтлан бодох бүртгэлтэй холбоотой зөрчилд зөвлөмж хүргүүллээ.

3.1 Төлбөрийн акт

Нэр бүхий ажилтнуудад 2,980.9 мянган төгрөгийн цалингийн нэмэгдэл, ээлжийн амралтын олговрыг илүү тооцож олгосон нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д “төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5-д ерөнхий нягтлан бодогч дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах” гэж заасныг тус тус зөрчсөн, “нийцсэн бөгөөд зохистой байх” гэсэн батламж мэдэгдлийг хангаагүй тул төлбөрийн акт тогтоосон

3.2 Албан шаардлага

1. Тээвэр шатахууны зардлын зарцуулалтад тавих дотоод хяналт хангалтгүйгээс батлагдсан төсвийг 3,780.5 мянган төгрөгөөр хэтрүүлэн, 2,488.5 мянган төгрөгийн өглөг үүсгэсэн,
2. Байгууллагын дотоод хяналтын нэгж нь ажилтнуудад олгосон 52,818.5 мянган төгрөгийн илүү цагийн болон шөнийн нэмэгдлийн баримтын бүрдүүлэлт, олголтод хяналтыг хангалтгүй хэрэгжүүлсэн байна.

Эдгээр нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах"; 6.4.8-д "төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх", Засгийн газрын 2011 оны 311 дүгээр тогтоолоор баталсан "Аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагаанд дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах нийтлэг журам"-ын 3.7.3-д "илэрсэн зөрчил, дутагдлын шалтгаан нөхцөлийг тодруулан зөрчлийг арилгуулах, дахин гаргуулахгүй байх талаар арга хэмжээ авах" гэж заасныг тус тус зөрчсөн нийцсэн бөгөөд зохистой байх" гэсэн батламж мэдэгдлийг хангаагүй тул албан шаардлага хүргүүлсэн.

3.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

Нягтлан бодох бүртгэлтэй холбоотой асуудал

1.Илрүүлэлт:

"Үдийн цай" хөтөлбөрт зориулан 2017 онд худалдан авсан 680.0 мянган төгрөгийн өртөгтэй, стандартын бус бараа материалыг өнөөдрийг хүртэл зарцуулаагүй, хугацаа дууссан байдалтай байна. Энэ нь Засгийн газрын 2024 оны 354 дүгээр тогтоолоор батлагдсан "Хүүхдийн хоолны түүхий эдийн зардлын хэмжээг шинэчлэн тогтоох тухай" журмын 5-д "Хүүхдийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээнд зохих стандартыг мөрдүүлж, хоолны цэсэд сүү, сүүн бүтээгдэхүүний хэмжээг нэмэгдүүлэх, хүнсний түүхий эд, бүтээгдэхүүн ханган нийлүүлэлтийг хувийн хэвшилтэй хамтран хэрэгжүүлэх" гэж заасныг тус тус зөрчсөн "нийцсэн бөгөөд зохистой байх" гэсэн батламж мэдэгдлийг хангаагүй байна.

Өгсөн зөвлөмж:

"Үдийн цай" хөтөлбөрт стандартын бус бараа материал худалдан авдаг зөрчлийг таслан зогсоох, эхэлж авсныг эхэлж зарлагадах аргыг ашиглан бараа материалыг зарлагадаж хэвших;

Нийцлийн аудиттай холбоотой асуудал

2.Илрүүлэлт:

Байгууллагад 2025 оны 10-12 дугаар сард гарсан 3 сул орон тооны мэдээллийг нийтэд зарлаагүй, ажлаас чөлөөлсөн ажилтныг буцаан томилохдоо хугацаатай гэрээг байгуулаагүй байна. Энэ нь Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.3.1-д "Мэдээлэл хариуцагч ажлын байрны сул орон тооны талаарх Мэдээллийг байнга ил тод, нээлттэй байлгана." гэж заасныг зөрчсөн, "нийцсэн бөгөөд зохистой байх" гэсэн батламж мэдэгдлийг хангаагүй

Өгсөн зөвлөмж:

Байгууллагад гарсан ажлын байрны сул орон тооны мэдээллийг хуулийн хугацаанд нийтэд зарлах, ажлаас чөлөөгдсөн ажилтныг буцаан томилохдоо хугацаатай гэрээ байгуулан, цалин хөлсийг олгох

Эдгээр зөвлөмжийг хэрэгжүүлэн, биелэлтийг 2026 оны 08 дугаар сарын 25 -ны өдрийн дотор төрийн аудитын байгууллагын Fas.audit.mn цахим системд тус тус мэдээлж, баталгаажуулна уу.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

4. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Хүснэгт 6. Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуул сан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
							Залруул сан		Залруу лаагүй			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
өглөгийн үлдэгдлийг 533.7 мянган төгрөгөөр, авлагын үлдэгдлийг 5,854.0 мянган төгрөгөөр алдаатай илэрхийлсэн	2	6,387.7			2	6,387.7	2	6,387.7				
үр дүнгийн тайланд зардлыг алдаатай тайлагнасан ныг алдаатай илэрхийлсэн	1	29,441.1			1	29,441.1	1	29,441.1				
Дүн	3	35,828.8			3	35,828.8	3	35,828.8				

Хүснэгт 7. Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Цалингийн нэмэгдлийг нэр бүхий ажилтнуудад илүү тооцож олгосон.	1	2,980.9	1	2,980.9				
илүү цагийн болон шөнийн нэмэгдлийн баримтын бүрдүүлэлт, олголтод хяналтыг хангалтгүй хэрэгжүүлсэн	1	52,818.5			1	52,818.5		
Тээвэр шатахууны зардлын төсвийг хэтрүүлсэн	1	3,780.5			1	3,780.5		
“Үдийн цай” хөтөлбөрт стандартын бус бараа материалыг худалдан авсан	1	680.0					1	680.0
Дүн	4	60,259.9	1	2,980.9	2	56,599.0	1	680.0

Хүснэгт 8. Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн тогтоомжтой холбоотой зөрчил								
2025 оны 10-12 дугаар сард гарсан 3 сул орон тооны мэдээллийг нийтэд зарлаагүй	1	0.00					1	0.00
Дүн	1	0.0					1	0.0